**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2025/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2025 он

Дарга,Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.24 № 116

танай ______________ -ны № ________________ -т

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.НЯМДАВАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 41,535.0 мянган төгрөгөөр тасарсан, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 776.0 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2,877.6 мянган төгрөгөөр тус тус тасарсан,

8225020342

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон байна.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

"Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 4 орон тоо нэмэгдсэн байна.

Сумын Орон нутгийн төсвийн орлогыг 456,458.9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 566,023.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 109,564.5 мянган төгрөгөөр буюу 124.0 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,158,691.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 115,743.7 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 14,300.0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 4,000.0 мянган төгрөг, Ерөнхий боловсролын сургуульд 3,727.0 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилтийг тус тус илүү олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 1,085,098.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 6 зорилт, 24 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 94.8 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 777,462.2 | 735,515.2 |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 332,710.8 | 265,429.1 |
| 33 | **АВЛАГА** | 153,151.1 | 106,306.1 |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | 16,434.5 | 17,934.5 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 178,153.5 | 220,553.3 |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | 103.0 | 8,383.0 |
| 360 | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 96,909.3 | 116,909.3 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 3,703,898.2 | 4,587,807.7 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,703,898.2 | 4,587,807.7 |
| 39200 | **Биет хөрөнгө** | 2,447,356.5 | 3,416,582.2 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 1,256,541.7 | 1,171,225.5 |
| 39400 | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | - | - |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 4,481,360.4 | 5,323,322.9 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 82,582.1 | 74,041.7 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 82,582.1 | 74,041.7 |
| 41300 | **Өглөг** | 82,582.1 | 74,041.7 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 4,398,778.2 | 5,249,281.2 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,398,778.2 | 5,249,281.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 206,320.4 | 206,320.4 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 126,951.8 | 126,951.8 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | 3,860,665.5 | 4,711,168.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 204,840.6 | 204,840.6 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,481,360.4** | **5,323,322.9** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 4,761,658.9 | 3,898,863.1 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 353,780.2 | 517,921.7 |
| 110 | Орлогын албан татвар | 199,022.0 | 434,799.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 213,430.5 | 457,008.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -14,408.5 | -22,209.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 110,610.0 | 74,687.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 44,148.2 | 8,435.4 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,614,266.0 | 1,117,005.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,614,266.0 | 1,117,005.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,793,612.7 | 2,263,935.8 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,896,757.8** | **2,064,052.4** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,896,757.8 | 2,064,052.4 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,575,927.5 | 1,965,027.8 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 411,015.1 | 704,425.7 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,370.3 | 88,007.6 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 407,602.1 | 474,098.9 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 78,051.5 | 82,444.8 |
| **2105** | Норматив зардал | 0.0 | 0.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 38,763.7 | 66,087.0 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 12,036.0 | 11,636.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 82,457.6 | 37,297.3 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 494,631.0 | 501,030.5 |
| **211** | ХҮҮ | 0.0 | 0.0 |
| **212** | ТАТААС | 0.0 | 0.0 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,320,830.4 | 99,024.6 |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 1,864,901.1 | 1,834,810.7 |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 0.0 | 0.0 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 704,471.4 | 994,300.0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 1,160,429.6 | 840,510.7 |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,239,324.7** | **3,239,324.7** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (976.1) | (976.1) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,238,348.6 | 3,238,348.6 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 1,160,429.6 | 1,160,429.6 |
| 10 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,398,778.2** | **4,398,778.2** |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,398,778.2 | 4,398,778.2 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 9,992.2 | 9,992.2 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,408,770.5 | 4,408,770.5 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 840,510.7 | 840,510.7 |
| 20 | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **5,249,281.2** | **5,249,281.2** |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

*2043 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,226,888.4** | **2,841,349.5** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 353,780.2 | 517,921.7 |
| 110 | Орлогын албан татвар | 199,022.0 | 434,799.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 213,430.5 | 457,008.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -14,408.5 | -22,209.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **113** | Хөрөнгийн албан татвар | 110,610.0 | 74,687.3 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 44,148.2 | 8,435.4 |
| **1180** | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 10,881.7 | 2,992.1 |
| **1181** | Газрын төлбөр | 6,263.2 | 5,443.3 |
| **1182** | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 27,003.3 | 0.0 |
| **1183** | Бусад татвар | 0.0 | 0.0 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 59,495.5 | 63,251.7 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 59,495.5 | 63,251.7 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,813,612.7 | 2,260,176.1 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,516,945.6** | **1,754,244.0** |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,516,945.6 | 1,754,244.0 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,176,115.2 | 1,658,979.1 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 412,875.1 | 674,445.5 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 51,370.3 | 77,366.4 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 105,454.3 | 473,613.0 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 82,103.6 | 88,092.0 |
| **2105** | Нормативт зардал | 0.0 | 0.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,776.7 | 69,862.0 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 12,036.0 | 11,636.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 378,124.5 | 43,753.3 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,374.6 | 220,211.0 |
| **211** | **ХҮҮ** | 0.0 | 0.0 |
| **212** | **ТАТААС** | 0.0 | 0.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,340,830.4 | 95,264.8 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 709,942.8 | 1,087,105.5 |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | 0.0 | 0.0 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 631,356.4 | 1,154,387.2 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 631,356.4 | 1,154,387.2 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 631,356.4 | 1,154,387.2 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 0.0 | 0.0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | -631,356.4 | -1,154,387.2 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | -109,000.0 | 0.0 |
| **14** | **Бусад эх үүсвэр** | 0.0 | 0.0 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 109,000.0 | 0.0 |
| **24** | **ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР** | 0.0 | 0.0 |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | 0.0 | 0.0 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | -30,413.6 | -67,281.7 |
| **101** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 363,124.4 | 332,710.8 |
| **20** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 332,710.8 | 265,429.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,957,855.2** | **2,693,891.9** | **263,963.3** | **91.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,714,740.4** | **1,671,311.9** | **43,428.5** | **97.5** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,599,486.1 | 1,576,047.1 | 23,439.0 | 98.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 674,822.2 | 674,445.5 | 376.7 | 99.9 |
| 210101 | Үндсэн цалин | 674,445.5 | 406,732.8 | 267,712.7 | 60.3 |
| 210102 | Нэмэгдэл | - | 221,654.3 | (221,654.3) | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 376.7 | 10,219.0 | (9,842.3) | |
| 210104 | Урамшуулал | - | 35,839.4 | (35,839.4) | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,125.0 | 77,366.4 | 6,758.6 | 92.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,225.0 | 53,743.3 | 4,481.7 | 92.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,530.0 | 5,848.9 | 681.1 | 89.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,645.0 | 3,018.8 | 626.2 | 82.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,145.0 | 2,920.0 | 225.0 | 92.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,580.0 | 11,835.4 | 744.6 | 94.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 482,575.4 | 473,613.0 | 8,962.4 | 98.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,640.0 | 40,320.4 | 5,319.6 | 88.3 |
| 210302 | Түлш, халаалт | 416,150.6 | 415,286.5 | 864.1 | 99.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 20,784.8 | 18,006.1 | 2,778.7 | 86.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 83,465.5 | 81,306.6 | 2,158.9 | 97.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,964.0 | 8,888.9 | 1,075.1 | 89.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 65,402.5 | 64,387.7 | 1,014.8 | 98.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,400.0 | 1,376.5 | 23.5 | 98.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600.0 | 598.4 | 1.6 | 99.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,099.0 | 6,055.1 | 44.0 | 99.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 121,400.0 | 120,196.3 | 1,203.8 | 99.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 35,000.0 | 34,155.3 | 844.7 | 97.6 |
| 210604 | Урсгал засвар | 86,400.0 | 86,041.0 | 359.1 | 99.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,946.0 | 11,636.0 | 310.0 | 97.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,946.0 | 11,636.0 | 310.0 | 97.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 31,752.0 | 29,386.3 | 2,365.7 | 92.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,500.0 | 25,963.1 | 536.9 | 98.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 172.0 | - | 172.0 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 800.0 | - | 800.0 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400.0 | 121.0 | 279.0 | 30.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,880.0 | 1,554.8 | 325.2 | 82.7 |
| 210807 | Газрын төлбөр | 2,000.0 | 1,747.4 | 252.6 | 87.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 109,400.0 | 108,097.0 | 1,303.0 | 98.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100,180.0 | 99,324.1 | 855.9 | 99.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,220.0 | 8,772.9 | 447.1 | 95.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 115,254.3 | 95,264.8 | 19,989.5 | 82.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 115,254.3 | 95,264.8 | 19,989.5 | 82.7 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 58,813.0 | 41,212.4 | 17,600.6 | 70.1 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,841.3 | 29,531.2 | 2,310.1 | 92.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,600.0 | 24,521.3 | 78.8 | 99.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,174,514.8 | 1,022,580.0 | 151,934.8 | 87.1 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,174,514.8 | 1,022,580.0 | 151,934.8 | 87.1 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 68,600.0 | - | 68,600.0 | - |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 68,600.0 | - | 68,600.0 | - |
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,957,855.2** | **2,619,119.8** | **338,735.4** | **88.5** |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,698,156.0 | 2,576,173.1 | 121,982.9 | 95.5 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,819,834.7 | 1,736,497.9 | 83,336.8 | 95.4 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 878,321.3 | 839,675.2 | 38,646.1 | 95.6 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 259,699.2 | 42,946.7 | 216,752.5 | 16.5 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,776.7 | 42,946.7 | (41,170.0) | |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 257,922.5 | - | 257,922.5 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 239,441.8 | (239,441.8) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 164,669.7 | (164,669.7) | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 180,499.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 180,499.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 176,739.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,785.4 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 6,295.4 |
| **210406** | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 490.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,336.0 |
| **210604** | Урсгал засвар | 1,336.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,367.0 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,367.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 157,250.9 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 157,250.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,759.8 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,759.8 |
| **213405** | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 3,759.8 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 180,499.0 |

| | | |
|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 180,499.0 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 177,508.0 |
| **131105** | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,991.0 |

## 3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар нийт 955.4 сая төгрөгийн 4 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.
Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- ЗДТГ-ын нийгмийн даатгал, татвартай холбоотой өглөг 40.6 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой өглөгөөр тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд 65.4 сая төгрөгийн устгах бичилтийг эдийн засгийн ангилал зөрчин хийсэн,
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих тусламж санхүүжилтийн орлого 839.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтээр тайлагнасан,
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь засгийн газрын хувь оруулсан капитал 9.8 сая төгрөгийг улсын төсвийн оруулсан хөрөнгөөр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 142.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 142.1 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн.

### 3.1.1 Харьяа байгууллагууд

Эрдэнэ сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 Эрдэнэ эрчим хүч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

### 3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 1,078.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 7 алдааг залруулж, 18.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 20.7 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

**3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 230.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 14 алдааг залруулж, 137.8 сая төгрөгийн 11 зөрчил илрүүлж, 9.2 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 128.5 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

**3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар өглөг, орлоготой холбоотой 955.4 сая төгрөгийн 4 алдааг залруулсан.
Аудитаар нийт 160.4 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс 142.0 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 22.0 сая төгрөгийн 1 заалт зөвлөмжийг хүргүүлж байна.

**3.3 Албан шаардлага**

1. Малын тоо толгойн албан татварын орлого 41.5 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.7 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2.8 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Эрдэнэ Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,485.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 1,308.7 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 176.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд борлуулах зорилгоор эзэмшиж байгаа 96.6 сая төгрөгийн халаалтын шугамын ажлыг хүлээж аваагүй, хийгээгүй болович 3 жил бүртгэлтэй байгаа нь. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;, 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт 2 дугаар бүлгийн (б)Нэн түрүүнд борлуулах зорилгоор эзэмшиж байгаа;-тай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө дансанд бүртгэлтэй



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Аймгийн төсвөөс 115.7 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн. Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 14.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 4.0 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуульд 3.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Эрдэнэ Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрдэнэ сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан | 4 | 955,459.0 | - | - | 4 | 955,459.0 | 4 | 955,459.0 | - | - | | - |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | 14 | 230,496.3 | - | - | 14 | 230,496.3 | 14 | 230,496.3 | - | - | | - |
| Эрдэнэ сумын Орон нутгийн хөгжлийн сан | 4 | 979,473.8 | - | - | 4 | 979,473.8 | 4 | 979,473.8 | - | - | | - |
| Эрдэнэ сумын Хоршоо хөгжүүлэх сан | 3 | 98,800.9 | - | - | 3 | 98,800.9 | 3 | 98,800.9 | - | - | | - |
| **Дүн** | **25** | **2,264,230.0** | **-** | **-** | **25** | **2,264,230.0** | **25** | **2,264,230.0** | **-** | - | - | - |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Бүгд | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрдэнэ сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан | 1 | - | 1 | - | - | - | 4 | 160,471.3 | - | - | 3 | 138,444.3 | 1 | 22,027.0 | - | - | - | - |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | 1 | - | 1 | - | - | - | 11 | 137,807.4 | 4 | 9,282.2 | 5 | 128,525.2 | 2 | - | - | - | - | - |
| Эрдэнэ сумын иргэдийн | | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төлөөлөгчдийн Хурал | 1 | - | - | - | - | 1 | 2 | 12,381.7 | - | - | 2 | 12,381.7 | - | - | - | - | - | - |
| Эрдэнэ сумын Орон нутгийн хөгжлийн сан | 1 | - | - | - | - | 1 | 1 | 8,383.0 | - | - | 1 | 8,383.0 | - | - | - | - | - | - |
| Эрдэнэ сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан | 1 | - | - | - | - | 1 | 1 | 18,000.0 | 1 | 18,000.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Эрдэнэ сумын Хоршоо хөгжүүлэх сан | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **6** | **-** | **2** | **-** | **-** | **4** | **19** | **337,043.4** | **5** | **27,282.2** | **11.0** | **287,734.2** | **3** | **22,027.0** | - | - | - | - |

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** **(мянган төгрөг)**

| **Байгууллагын нэр** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| **Дүн** | **1** | - | **-** | **-** | **-** | - | **1** | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 5 | 1 | 4 | | | 1 | | |
| 2 | ТТЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | | **2** | | | | **2** | | |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР